



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/040/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Ч.Мөнхтогтох
Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5-6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11-12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	13-14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	17
3.5.3 Нэмэлт төсөв.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТЭС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЦЭРЭНЖАВ
ТАНАА

2026.02.24 № УВА-2026/040/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

8525050506

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	85,263,650.00	287,121,962.00
33	АВЛАГА	32,268.00	199,585,000.00
335	Бусад авлага	32,268.00	199,585,000.00
3351	Байгууллагаас авах авлага	32,268.00	199,585,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	85,231,382.00	87,536,962.00
354	Хангамжийн материал	29,461,207.00	31,766,787.00
35410	Бичиг хэргийн материал	440,000.00	120,000.00
35420	Аж ахуйн материал	6,526,007.00	7,891,007.00
35450	Барилгын засварын материал	51,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	22,444,200.00	23,755,780.00
35600	Мал амьтад	55,770,175.00	55,770,175.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,533,200,613.31	6,370,239,724.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,533,200,613.31	6,370,239,724.61
392	Биет хөрөнгө	6,468,271,213.31	6,305,310,324.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,061,062,606.08	5,347,000,830.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-802,186,869.87	-1,034,970,192.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	550,604,546.00	480,604,546.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-126,150,505.37	-175,292,929.85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	465,657,687.40	470,817,687.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-188,434,547.84	-216,379,538.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,160,414.50	44,178,914.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,035,642.81	-40,345,700.64
39209	Зам, гүүрийн байгууламж	1,442,736,342.50	1,442,736,342.50
39210	Хуримтлагдсан элэгдэл	-72,136,817.16	-144,273,634.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,300,000.00	21,300,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,280,000.12	-9,040,000.16
39217	Ном	118,974,000.00	118,974,000.00
393	Биет бус хөрөнгө	64,929,400.00	64,929,400.00
39301	Програм хангамж	1,460,000.00	1,460,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,460,000.00	-1,460,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	64,929,400.00	64,929,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,618,464,263.31	6,657,361,686.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,812,780.95	212,083,312.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,812,780.95	212,083,312.18
413	Өглөг	11,812,780.95	212,083,312.18
4136	Бусад өглөг	11,812,780.95	212,083,312.18
41361	Байгууллагад төлөх өглөг	11,812,780.95	212,083,312.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,606,651,482.36	6,445,278,374.43
51	Засгийн газрын хувь оролцоо	6,606,651,482.36	6,445,278,374.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	484,321,503.00	484,321,503.00
51101	Өмч: - төрийн	484,321,503.00	484,321,503.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,415,632,443.07	5,254,259,335.14
51210	Өмнөх үеийн үр дүн	5,415,632,443.07	5,415,632,443.07
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-161,373,107.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	706,697,536.29	706,697,536.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,618,464,263.31	6,657,361,686.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,633,828,587.00	1,508,228,291.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,220,633,588.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,220,633,588.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,220,633,588.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,220,633,588.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,413,194,999.00	1,508,228,291.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	273,235,899.00	308,005,391.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,300,100.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	203,456,799.00	304,501,891.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,479,000.00	1,503,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,139,959,100.00	1,200,222,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,139,959,100.00	1,200,222,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,781,077,096.89	1,634,601,398.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,581,174,187.89	1,634,601,398.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,510,921,992.35	1,629,617,967.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	795,813,230.26	947,145,594.15
210101	Үндсэн цалин	547,670,934.97	575,897,642.31
210102	Нэмэгдэл	175,542,786.29	322,735,985.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,677,000.00	24,098,000.00
210104	Урамшуулал	22,556,900.00	12,175,650.25
210105	Гэрээт ажлын хөлс	36,365,609.00	12,238,316.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,837,226.76	118,078,760.59
210201	Тэтгэврийн даатгал	73,738,226.76	86,382,262.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,228,000.00	10,112,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	3,057,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,871,000.00	18,526,998.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,127,317.95	42,029,856.15
210301	Гэрэл, цахилгаан	8,657,249.32	10,258,368.45
210302	Түлш, халаалт	34,393,048.63	31,577,997.70
210303	Цэвэр, бохир ус	1,077,020.00	193,490.00
2104	Хангамж, бараа материалын зардал	87,973,341.00	50,017,214.00
210401	Бичиг хэрэг	5,735,400.00	2,299,550.00
210402	Тээвэр, шатахуун	46,156,270.00	46,149,164.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,065,900.00	1,568,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,109,771.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	29,906,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,780,000.00	2,931,000.00
210604	Урсгал засвар	23,780,000.00	2,931,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,418,000.00	7,854,600.00
210702	Дотоод албан томилолт	8,418,000.00	7,854,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,944,785.44	3,373,210.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,000.00	97,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	279,250.00	276,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,335.44	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	572,000.00	3,000,000.00
210807	Газрын төлбөр	1,332,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	448,028,090.94	458,187,732.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	116,826,348.00	35,860,120.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	2,250,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	330,701,742.94	420,077,612.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,252,195.54	4,983,431.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,258,100.00	1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,338,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,920,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	994,095.54	3,483,431.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	994,095.54	3,483,431.34
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	199,902,909.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	199,902,909.00	00.00
223001	Бусад хөрөнгө	199,902,909.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	852,751,490.11	-126,373,107.85
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	35,000,000.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	35,000,000.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-35,000,000.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	852,751,490.11	-161,373,107.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,413,194,999.00	1,508,228,291.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,413,194,999.00	1,508,228,291.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	273,235,899.00	308,005,391.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,300,100.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	203,456,799.00	304,501,891.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,479,000.00	1,503,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,139,959,100.00	1,200,222,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,139,959,100.00	1,200,222,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,199,506,090.00	1,413,326,141.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,199,506,090.00	1,413,326,141.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,129,253,894.46	1,208,757,709.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	785,002,665.07	945,538,097.92
210101	Үндсэн цалин	536,860,369.78	574,290,146.08

210102	Нэмэгдэл	175,542,786.29	322,735,985.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,677,000.00	24,098,000.00
210104	Урамшуулал	22,556,900.00	12,175,650.25
210105	Гэрээт ажлын хөлс	36,365,609.00	12,238,316.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,126,200.00	117,957,299.59
210201	Тэтгэврийн даатгал	72,027,200.00	86,260,801.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,228,000.00	10,112,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	3,057,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,871,000.00	18,526,998.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,159,585.95	41,978,558.15
210301	Гэрэл, цахилгаан	8,689,517.32	10,226,100.45
210302	Түлш, халаалт	34,393,048.63	31,558,967.70
210303	Цэвэр, бохир ус	1,077,020.00	193,490.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,853,120.00	38,013,300.00
210401	Бичиг хэрэг	3,460,000.00	1,277,550.00
210402	Тээвэр, шатахуун	31,739,220.00	34,292,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,065,900.00	1,568,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	788,000.00	515,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,817,000.00	9,058,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000.00	5,160,000.00
210602	Тавилга	00.00	1,018,500.00
210604	Урсгал засвар	21,797,000.00	2,880,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,208,000.00	7,854,600.00
210702	Дотоод албан томилолт	8,208,000.00	7,854,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,269,785.44	3,576,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	407,000.00	300,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	279,250.00	276,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,335.44	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,000.00	3,000,000.00
210807	Газрын төлбөр	1,332,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,817,538.00	44,780,644.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	128,610,038.00	42,498,644.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,207,500.00	2,282,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,252,195.54	204,568,431.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,258,100.00	1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,338,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,920,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	994,095.54	203,068,431.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	994,095.54	203,068,431.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	213,688,909.00	94,902,150.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	213,688,909.00	94,902,150.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	213,688,909.00	94,902,150.00

2200	Дотоод эх үүсвэрээр	213,688,909.00	94,902,150.00
223001	Бусад хөрөнгө	199,902,909.00	94,902,150.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,786,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-213,688,909.00	-94,902,150.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	484,321,503.00	706,697,536.29	5,415,632,443.07	00.00	6,606,651,482.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,321,503.00	706,697,536.29	5,415,632,443.07	00.00	6,606,651,482.36
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	484,321,503.00	706,697,536.29	5,415,632,443.07	00.00	6,606,651,482.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	484,321,503.00	706,697,536.29	5,415,632,443.07	00.00	6,606,651,482.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-161,373,107.93	00.00	-161,373,107.93
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,321,503.00	706,697,536.29	5,254,259,335.14	00.00	6,445,278,374.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,200,222,900.00	1,197,213,025.66	3,009,874.34	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,200,222,900.00	1,197,213,025.66	3,009,874.34	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,198,722,900.00	1,195,713,025.66	3,009,874.34	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	945,538,098.73	945,538,097.92	0.81	100.0
210101	Үндсэн цалин	584,985,442.62	574,290,146.08	10,695,296.54	98.2
210102	Нэмэгдэл	311,845,105.86	322,735,985.59	10,890,879.73	103.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,762,000.00	24,098,000.00	-4,336,000.00	121.9
210104	Урамшуулал	11,287,650.25	12,175,650.25	-888,000.00	107.9
210105	Гэрээт ажлын хөлс	17,657,900.00	12,238,316.00	5,419,584.00	69.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,957,500.00	117,957,299.59	200.41	100.0
210201	Тэтгэврийн даатгал	85,585,300.00	86,260,801.00	-675,501.00	100.8
210202	Тэтгэмжийн даатгал	10,223,300.00	10,112,500.00	110,800.00	98.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	500,400.00	00.00	500,400.00	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,557,400.00	3,057,000.00	500,400.00	85.9
210205	Эрүүл мэндийн даатгал	18,091,100.00	18,526,998.59	-435,898.59	102.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,978,666.60	41,978,558.15	108.45	100.0
210301	Гэрэл, цахилгаан	11,608,966.60	10,226,100.45	1,382,866.15	88.1
210302	Түлш, халаалт	29,267,900.00	31,558,967.70	-2,291,067.70	107.8
210303	Цэвэр, бохир ус	1,101,800.00	193,490.00	908,310.00	17.6
2104	Хангамж, бараа материалын зардал	31,767,324.67	31,763,800.00	3,524.67	100.0
210401	Бичиг хэрэг	1,279,083.86	1,277,550.00	1,533.86	99.9
210402	Тээвэр, шатахуун	28,044,740.81	28,042,750.00	1,990.81	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,568,500.00	1,568,500.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	515,000.00	515,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,347,000.00	7,340,000.00	7,000.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,160,000.00	5,160,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,187,000.00	2,180,000.00	7,000.00	99.7
2107	Томилолт, зочны зардал	7,854,600.00	7,854,600.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	7,854,600.00	7,854,600.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,576,710.00	3,576,710.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,500.00	300,500.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	276,210.00	276,210.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42703000.00	39703960.00	2,999,040.00	93.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,421,000.00	39,421,960.00	2,999,040.00	92.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	282,000.00	282,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1500000.00	1500000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,200,222,900.00	1,200,222,900.00	0.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,200,222,900.00	1,200,222,900.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,200,222,900.00	1,200,222,900.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		107,946,834.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		13,044,684.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		13,044,684.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,249,500.00
210402	Тээвэр, шатахуун		6,249,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,718,500.00
210602	Тавилга		1,018,500.00
210604	Урсгал засвар		700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		5,076,684.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,076,684.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		94,902,150.00
2200	Дотоод эх үүсвэрээр		94,902,150.00
223001	Бусад хөрөнгө		94,902,150.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		308,005,391.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		308,005,391.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		304,501,891.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,503,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанартай, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тэс сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузль сууриар хөтөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Тэс сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acoulous" программ хангамж ашигладаг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,897.4 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	32.3	199,585.0	199,552.7
Бараа материал	85,231.4	87,536.9	2,305.5
Үндсэн хөрөнгө	6,533,200.6	6,370,239.7	-162,960.9
Нийт хөрөнгө	6,618,464.3	6,657,361.7	38,897.4
Өр төлбөр	11,812.8	212,083.3	200,270.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,606,651.5	6,445,278.4	-161,373.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,618,464.3	6,657,361.7	38,897.4

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 199,585.0 мянган төгрөг болж 199,552.9 мянган төгрөгөөр өссөн нь наадмын талбайн санхүүжилтийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 87,536.9 мянган төгрөг болж 2,305.5 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,370,239.7 мянган төгрөг болж 162,960.9 мянган төгрөгөөр буурсан хөрөнгийн элэгдэл болон Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 70,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 212,083.3 мянган төгрөг болж 200,270.5 мянган төгрөгөөр өссөн нь наадмын талбайн үлдэгдэл санхүүжилт 199,585.0 мянга, ХХОАТ-ын өглөг 13,170.3 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 121.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,445,278.4 мянган төгрөг болж 161,373.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,346,533.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 146,310.1 мянган төгрөгөөр бууруулж, 1,200,222.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,200,222.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,200,222.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагаанд 1,197,213.0 мянган төгрөгийг зарцуулж, 3,009.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,197,213.0 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Үндсэн үйл ажиллагааны зардал : 70106/80101	628,690.0	628,688.19	1,490.81	100.0
2	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Баг хорооны ҮА зардал : 70106/80106	370,934.5	370,932.9	1,533.86	100.0
3	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал : 70106/80111	42,757.6	42,750.5	7,108.45	100.0
4	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- нийтлэг үйлчилгээний зардал : 70106/80112	113,559.8	113,559.1	701.22	100.0
5	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- мэдээлэл сурталчилгааны зардал : 70106/80205	0.0	0.0	0	0.0
6	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- ажил олгогчоос олгох тэтгэмж зардал : 70106/80802	1,500.0	1,500.0	0	100.0
7	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- орон нутгийн нөөц хөрөнгийн зардал : 70106/81102	30,000.0	29,993.6	6,390.0	100.0
8	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Мал тооллогын зардал : 70106/81507	1,750.0	1,748.9	1,050.0	99.9
9	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Хур.Хог хаягдал,орчны бохирдлын зардал : 70106/82212	360.0	360.0		100.0
10	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Улсын их баяр наадмын зардал : 70106/82801	5,000.0	4,597.6	402.4	92.0
11	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх зардал : 71413/81701	4,841.0	2,251.8	2,589.2	46.5
12	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Ахмад настны хөгжил хамгаалал зардал : 72208/81549	830.0	830.0	0.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий судалгааны дүн

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	1,460.0	Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн тайлан гаргадаг 1,460.0 мянган төгрөгийг 1 программ байна.
2	Унаа, хоолны зарцуулалт	24,098.0	2025 онд хоолны хөнгөлөлт 24,098.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.
3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал	0	Зардал гараагүй
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0	Зардал гараагүй
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0	Зардал гараагүй
6	Орон тоо	945,538.1	Увс аймгийн Тэс сумын Засаг даргын тамгын газар нь 2025 онд батлагдсан орон тоо 19, гүйцэтгэлээр 19, гэрээт 4, нийт 23 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж цалин урамшуулалд 945,538.1 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 306,501.9 мянга, Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,503.5 мянга, нийт 308,005.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнээс: Хөрөнгийн зардалд 94,902.2 мянга, тээвэр, шатахууны зардалд 6,249.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 1,718.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд, 5,076.7 мянга, нийт 107,946.8 мянган төгрөгийг зарцуулж 200,058.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тэс сумын Засаг даргын тамгын газар тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тэс сумын Засаг даргын тамгын газар нь бичиг хэргийн материал 1,277.6 мянга, тээвэр, бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлд 515.0 мянга, шатахууны зардалд 28,042.7 мянга, урсгал засварын материал 2,880.0 мянга, нийт 32,715.3 мянган төгрөгөөр худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,781,077.1 мянган төгрөгийн 1.0 хувиар буюу 17,810.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 14,248.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,634,601.4 мянган төгрөгийн 1.0 хувиар буюу 16,346.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 13,076.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тэс сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 168, хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 1/56 тоот албан бичгээр биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тэс сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийн хавсралтаар баталсан ч сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/03 дугаар тушаалаар тамгын газрын бүтэц, орон тоо, цалин нэмэгдлийг батлахдаа батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй сантехникч, 4 багийн төвийн сахиулыг гэрээтээр цалинжуулан ажиллаж байгааг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28.0 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал
 - 1.1. Илрүүлэлт: Монгол улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар " Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолыг зөрчиж 2025 онд тээвэр шатахууны зардлаас 28.0 сая төгрөгөөр шатах тослох материал шууд худалдан авалт хийсэн байна.
 - 1.2. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2024 оны 02 дугаар " Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолыг мөрдөж ажиллах.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон босго үнийг мөрдөж ажиллаагүй	1	28.0					1	28.0
Дүн								
Нийт дүн	1	28.0					1	28.0

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Ч.МӨНХТОГТОХ/

2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр